


Манай орны 6 дугаар сарын агаарын дундаж температур (1991-2020 оны дунджаар) Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар 12°C (53.6°F) –аас хүйтэн, говь-цөлийн бүс нутгаар +18.1°C (64.6°F) –аас +25°C (77°F), бусад нутгаар 12.1°C –аас +18°C (53.8°F –аас 64.4°F) дулаан байдаг байна.


Монгол орны хэмжээнд 6 дугаар сард ойролцоогоор жилийн нийлбэр хур тунадасны 18 хувь нь ордог. Тус сард төвийн болон нутгийн хойд хэсгээр 50.1-95 мм, говь-цөлийн бүс нутгаар 5-25 мм бусад нутгаар 25.1-50 мм тунадас ордог байна.



Зураг 1. 1991-2020 оны 6 дугаар сарын агаарын дундаж температур, нийлбэр нийлбэр хур тунадасны орон зайн тархалт


2026 оны 6 дугаар сарын агаарын дундаж температур өмнөх жилээс -3°C-аар, ОЖД-аас -1.5°C-аар тус тус хүйтэн байсан бөгөөд 1940 оноос хойш тохиолдож байгаа 18 дахь хүйтэн сар болж өнгөрлөө. Сарын дундаж агаарын температурын ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзэхэд (Зураг 2) нийт нутгийн 57.4% нь ОЖД-аас -1.0–ээс -5.0°C-аар хүйтэн, 22.5% нь дунджийн орчим, 20.2% нь дунджаас дулаан байжээ.

Тус сард Монгол орны хэмжээнд дунджаар 30.2 мм хур тунадас орсон нь өмнөх жилээс 5.4%-иар ахиу, ОЖД-аас 14.7%-иар бага байсан бөгөөд 1940 оноос хойш тохиолдож байгаа 32 дахь бага тунадастай сар болж өнгөрлөө. Сарын нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзвэл (Зураг 2) нийт нутгийн 21.7% нь дунджаас ахиу, 53.5% нь дунджаас бага, 24.8% -д ОЖД-ийн орчим хур тунадас унасан байна.




Зураг 2. 2026 оны 6 дугаар сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын оронзайн тархалт

Монгол орноор болон дөрвөн бүсээр ангилан тооцоолсон 6 дугаар сарын хоногийн агаарын температурын явцыг авч үзэхэд (Зураг 3) төв, өмнө, зүүн зүгийн нутгаар сарын ихэнх хугацаанд агаарын температур ОЖД-аас -0.3 -аас -9.5°C -аар хүйтэн байжээ. Харин баруун бүс нутгаар ихэнх хугацаанд агаарын температур ОЖД-аас $+0.3$ -аас $+5.9^{\circ}\text{C}$ -аар дулаан байсан байна. Хур тунадасны хувьд 2 дугаар 10 хоногт зүүн болон төвийн нутгаар харьцангуй ахиу хур тунадас орсон бол бусад хугацаанд нийт нутгаар харьцангуй бага хур тунадас оржээ.




Зураг3. Хоногийн дундаж агаарын температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлт

Агаарын үнэмлэхүй их температур 30°C -ыг давж халсан өдрийн тоо Баянхонгорын Шинэжинст сум Эхийнголд 24, Говь-Алтайн Тооройд 22, Ховдын Байтагт 18, Өмнөговийн Булган, Ховдын Зэрэг, Говь-Алтайн Ажбогд 10-15, бусад нутгаар 10-аас цөөн буюу ажиглагдаагүй байна.



Зураг 4. 30°C -аас халуун өдрийн өдрийн тооны орон зайн тархалт

Энэ сард агаарын температурын үнэмлэхүй их утга Увс аймгийн Тэс суманд 42.3°C , үнэмлэхүй бага утга Улаанбаатар хотын Тэрэлж орчимд -5.2°C хүрч ажиглагдсан. Хөрсний температурын үнэмлэхүй их утга Сүхбаатар аймгийн Баяндэлгэр суманд 71°C , үнэмлэхүй бага утга Улаанбаатар хотын Тэрэлж орчимд -8°C хүрч хүйтэрсэн байна. Хоногт хамгийн ихдээ Улаанбаатар хотын Буян-Ухаа орчимд 28-ны өдөр 39.4 мм тунадас орсон. Харин даралтын үнэмлэхүй их утга Сэлэнгийн Сүхбаатарт 947.1гПа, бага утга Баянхонгорын Баянбулагт 769.7гПа хүрч тус тус ажиглагдсан. Салхины хурд хамгийн их нь Өмнөговь аймгийн Цогт-Овоо суманд 33 м/с хүрчээ .



Зураг 5. Тус сард ажиглагдсан экстремаль утгууд